

**“Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх”
хөтөлбөрийн тухай**

ЗЭЭЛИЙН ХҮҮ БУУРАХ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Оршил

Монгол улсын Их хурлын 2010 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 68 дугаар тогтоолоор “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэл”-ийг баталсан бөгөөд уг тогтоолд “Зээлийн хүү бууруулах эдийн засгийн зохистой орчныг бүрдүүлэх хөтөлбөр боловсруулан хамтран хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн Газар /С.Батболд/, Монголбанк /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хороо /Д.Баярсайхан/-нд даалгасугай.” гэж заасан билээ.

Уг заалтыг хэрэгжүүлэхийн тулд Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хурлын протоколыг үндэслэн Монголбанкны ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны даргын хамтарсан 149/58/38/32 тоот тушаалаар “Зээлийн хүү буурах эдийн засгийн болон хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх хөтөлбөр”-ийг хамтран боловсруулж, хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаа.

Тус ажлын хэсэг нь зээлийн хүүний түвшинг захиргаадалтын аргаар бус харин эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар бууруулах нь зохистой гэж үзсэн. Учир нь хүүгийн түвшинг дорвитой бууруулж чадсан орнуудын туршлагаас харахад захиргаадалтын аргаар бус харин эдийн засаг, санхүүгийн таатай орчныг бүрдүүлэх замаар уг асуудлыг шийдвэрлэж байна. Монголбагнаас 2010 онд хийсэн зээлийн хүү, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаарх суурь судалгааны үр дүн болон тус оны 11 дүгээр сард Засгийн газар, олон нийт, банк, санхүүгийн байгууллагын төлөөллийг оролцуулсан нээлттэй хэлэлцүүлгийн санал, зөвлөмжөөс харахад юуны өмнө тогтворгүй инфляци, инфляцийн хүлээлт өндөр, хадгаламжийн зах зээл дээрх үнийн өрсөлдөөн болон зах зээлийн эрсдэл өндөр байгаа зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч байна. Зээлийн хүү нь микро хүчин зүйлс болох банкуудын үйл ажиллагаа болон макро хүчин зүйлс болох санхүүгийн зэх зээлийн хөгжил, макро эдийн засгийн болон эрх зүйн орчны хүчин зүйлсээр тодорхойлогдож байна. Манай улсын хувьд, зээлийн хүү буурахгүй байгаа нь тогтворгүй инфляци, инфляцийн хүлээлт өндөр, хадгаламжийн зах дээр үнийн өрсөлдөөн болон зах зээлийн эрсдэл өндөр байгаа зэрэг олон хүчин зүйлсээс хамаарч байна. Иймд хүүний түвшинг захиргаадалтын аргаар бус харин эдийн засаг, санхүү, хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлэх замаар бууруулах нь зохистой гэж үзэж байгаа бөгөөд дээрх хөтөлбөрт зээлийн хүү буурах зах

ТӨСӨЛ

зээлийн орчинг бүрдүүлэх макро бодлогын чиглэл, түүний үндэслэл, ач холбогдол болон авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар тусгасан билээ.

“Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх” хөтөлбөрийн эхний хувилбарыг боловсруулан 2011 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл (СТБЗ)-д танилцуулсан бөгөөд тус хурлаас Сангийн яам, Монголбанк, СЗХ, ҮХШХ-оос хамтарсан ажлын хэсэг байгуулах шийдвэр гарч 3 дугаар сард ажлын хэсгийн тушаал гарсан бөгөөд АХ-ийн ахлагчаар тэргүүн дэд ерөнхийлөгч Б.Жавхлан томилогдон ажиллав. Тус ажлын хэсэг нь хөтөлбөрийг шинэчлэн найруулж, боловсруулан, Сангийн яам, ҮХШХ, СЗХ болон Монголбанк, Арилжааны банкууд, болон Азийн Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудад танилцуулж, холбогдох саналуудыг тусгасан. Мөн хөтөлбөрийг хэрэгжүүлэх тал дээр Азийн Хөгжлийн Банкнаас техникийн туслалцаа авахаар харилцан тохиролцсон бөгөөд цаашид энэ чиглэлд хамтран ажиллахаар болсон.

“Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөр”-ийн төслийг боловсруулан 2011 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхэд Засгийн газрын хуралдаанд танилцуулсаны үндсэн дээр Монголбанкны Ерөнхийлөгч /Л.Пүрэвдорж/, Санхүүгийн зохицуулах хорооны дарга /Д.Баярсайхан/, Сангийн сайд /С.Баярцогт/, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга /Ч.Хашчулуун/ нарын хамтарсан тушаалаар батлуулах нь зүйтэй гэж үзсэн бөгөөд Засгийн газрын хуралдаанаар оруулан танилцуулахаар 2011 оны 7 дугаар сарын 4-ний өдөр СЯ-д хүргүүлсэн билээ.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 9 дугаар сарын 07 -ны өдрийн хуралдаанаар “Зээлийн хүү буурах зах зээлийн орчинг бүрдүүлэх хөтөлбөрийн төсөл”-ийг хэлэлцэж, хөтөлбөрийг хамтарч батлан хэрэгжүүлэхийг Сангийн сайд С.Баярцогт, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуунд даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж, Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайханд зөвлөсөн бөгөөд уг хөтөлбөрийн биелэлтийг жил тутам Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгаад байна.


Зээлийн хүүгийн өнөөгийн түвшин

Төгрөгийн хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2010 оны эцэст 10.7 хувь болж өмнөх оноос 2.2 нэгж хувиар, зээлийн жигнэсэн дундаж хүү 17.9 хувь болж өмнөх оны мөн үеэс 2.9 нэгж хувиар тус тус буурч байсан. Түүнчлэн 2011 оны 8 дугаар сарын байдлаар төгрөгийн хадгаламжийн дундаж хүү 10.3 хувь болж өмнөх оны мөн үеэс даруй 1.4 нэгж хувиар, 1 дүгээр улирлаас 0.2 нэгж хувиар тус тус буурлаа. Зээлийн жигнэсэн дундаж хүүний хувьд 17.2 хувь болж, өмнөх оны мөн үеэс даруй 3.1 нэгж хувиар буурч, харин өмнөх улирлаас 1.5 нэгж хувиар өсөөд байна. Өөрөөр хэлбэл, оны эхний хагаст зээлийн хүүгийн бууралт хадгаламжийн хүүгийн бууралтаас илүү хурдацтай байсан, харин сүүлийн 2 сард зээлийн хүү бага зэрэг өссөн нь хүүгийн зөрүү өссөнтэй холбоотой байна. Зээлийн хүү буурахад банкны


ТӨСӨЛ

салбарын чанаргүй зээл нэлээд саад болж байгаа, үүнийг шийдвэрлэх талаар Монголбанкнаас банкуудын зохистой харьцааг өсгөх, тэдгээрийн эрсдэл хуримтлуулах хандлагаас сэргийлэх макро зохистой бодлогын арга хэрэгслийг хэрэглэх зэрэг шат дараатай арга хэмжээ авч байна. 2009 оны эцэст чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 17.4 хувь байсан бол 2010 оны эцэст 11.5 хувь болж 5.7 нэгж хувиар, 2011 оны 8 дугаар сард 7.7 хувь болж буураад байна. Валютын зээлийн болон хадгаламжийн хүүгийн түвшин оны эхний хагаст төгрөгийн гадаад валюттай харьцах ханш чангарсаны улмаас бага хэмжээгээр өсөх хандлагатай байлаа. Хадгаламжийн хүүгийн түвшинд нөлөөлөгч хүчин зүйлсийг тодорхойлох зорилгоор хадгаламжийн хүүний талаарх түүвэр судалгааг 2010 онд явуулж, судалгааны үр дүнг шийдвэр гаргалтанд ашиглаж, энэхүү түүвэр судалгааг зээлийн судалгаагаар өргөтгөн улирал тутам явуулж байна.

Зураг 1. Төгрөгийн зээл, хадгаламжийн хүү



Зураг 2. Валютын зээл, хадгаламжийн хүү



Зээлийн хүүд нөлөөлөгч хүчин зүйлс, тулгамдаж буй асуудлууд

Санхүүгийн голлох байгууллагуудын шийдвэр, харилцагчийн мөнгөө хадгалуулах, зээл авах эсэх нь макро эдийн засгийн суурь нөхцлүүдээс хамаарч байдаг. Зээлийн хүүг бууруулахад хамгийн гол нөлөөтэй хүчин зүйл нь нам тогтвортой инфляци урт хугацаанд хадгалагдах явдалд оршиж байна. Инфляци нам түвшинд тогтвортой урт хугацаанд байвал банкуудын тогтвортой үйл ажиллагаа урт хугацаанд хангагдаж, иргэдийн банкинд итгэх итгэл нэмэгдэж, банкуудын гол эх үүсвэр болох хадгаламжийн хэмжээ нэмэгдэж, улмаар зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэргээр зээлийн хүү буурахад эергээр нөлөөлнө. Манай орны инфляци өндөр хэлбэлзэлтэй, хүлээлт өндөртэй байгаа нь хадгаламж эзэмшигчдийн хүүгээс олох ирээдүйн орлого өндөр байх тохиолдолд банкинд хадгаламжаа байршуулах сонирхлыг нэмэгдүүлж, энэ нь банкуудын татан төвлөрүүлэх хөрөнгийн зардлыг бууруулах нөхцлийг бүрдүүлэхгүй, хадгаламж татах өртөг өндөр тогтож, улмаар зээлийн хүү өндөр хэвээр хадгалагдах хүчин зүйл болж байна. Инфляцийн хүлээлт тогтворжих хүртэл үнийн тогтвортой

ТӨСӨЛ

байдлыг хангахад чиглэсэн бодлогыг тууштай, олон нийтэд ил тод баримтлах, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх хэлбэр, авах бодлогын арга хэмжээний талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, төсвийн хэт тэлэх бодлого явуулахгүй байх шаардлагатай байна. Энэ нь инфляцийн хүлээлтийг удирдах боломжийг нэмэгдүүлж, мөнгөний бодлогын бие даасан байдлыг бэхжүүлж, инфляцийг хөөрөгдөхгүй, нам түвшинд тогтвортой хадгалах үндсэн нөхцлүүд болж байна.

Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангахад дотоод эдийн засагт үзүүлэх гадаад шокийн нөлөөг баялгийн сан байгуулах, үндэсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг замаар бууруулах, богино хугацаатай хөрөнгийн дотогшлох урсгалд тодорхой шалгуур тавих замаар гадаад гэнэтийн шокоос шалтгаалсан хөрөнгийн гадагшлах урсгалын эрсдлийг бууруулах, урт хугацаатай гадаадын хөрөнгө оруулалтыг илүүтэй татах орчныг бүрдүүлэх шаардлагатай байна.

Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөгжил сул байгаа нь хувийн секторын мөнгө босгох боломжийг хязгаарлаж, банкны санхүүжилтээс хараат хэвээр байх, санхүүгийн салбар дахь банкны давамгайлал багасахгүй байх, банкнаас зээл авахаас өөр санхүүжилтийн сонголтгүй болгож, улмаар банкууд санхүүгийн зуучлалын өртгийг өндөр түвшинд хадгалахад нөлөөлж байна. Хөрөнгийн захыг хөгжүүлж, үр ашигтай, жигд, тасралтгүй үйл ажиллагаагаа явуулах эдийн засаг, хууль эрх зүйн орчныг бүрдүүлж, урт хугацаат, хямд эх үүсвэр татах боломжийг бүрдүлдэг санхүүгийн хэрэгслүүдийг олшруулж, хөрөнгийн захын хөрвөх чадварыг сайжруулах нь зээлийн хүү буурах чухал хүчин зүйлсийн нэг болоод байна. Нөгөөтэйгүүр, богино хугацаанд илүүдэл эх үүсвэрээ байршуулах хөрвөх чадвар сайтай үнэт цаас, бонд зэрэг санхүүгийн хэрэгслүүд түгээмэл биш байгаа нь банкууд илүүдэл хөрөнгөө оновчтой байршуулах боломжийг хязгаарлан, өгөөж багатай барьж, алдагдсан боломжийн зардлыг зээлийн хүүг өндөр тогтоох замаар нөхөхөд хүргэж байна.

Банкууд том хадгаламж эзэмшигчдийг татах зорилгоор зах зээлийн бус өндөр хүүг төлөх, том хадгаламж эзэмшигчид мэдээллийн болон гэрээний давуу талаа ашиглан нэг банкнаас нөгөө банк руу хадгаламжаа шилжүүлэх замаар хүүг өсгөх, зарим жижиг, дунд банкууд зах зээлд эзлэх хэмжээгээ нэмэгдүүлэх зорилгоор зах зээлийн бус өндөр хүүг амлах зэрэг үзэгдлүүд зээлийн хүү буурахгүй байхад нөлөөлж байна. Энэ байдлыг сааруулахын тулд банкны эх үүсвэрийн төрлийг, тэр дундаа гадаад эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хадгаламжийн даатгалын сонгодог тогтолцоог нэвтрүүлэх, хадгаламж эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах, банкуудын үйлчилгээний талаарх үнэн бодит мэдээллийг олон нийтэд хүртээх, нэг өмчлөлтэй банкуудыг нэгтгэх шаардлагатай байна.

Банкны өмчлөгчид болон гүйцэтгэх удирдлагын ашиг сонирхлын тэнцвэрт байдал алдагдсанаас холбогдох этгээд, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ зохистой харьцаанаас хэтрэх зэргээр банкны үйл ажиллагаа доголдох, зээлийн эрсдлийг нэмэгдүүлэх, улмаар банкны салбарын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Банкны салбар дахь байгууллагын зохистой засаглалыг бэхжүүлэх, ил тод, нээлттэй,

ТӨСӨЛ

шударга ёсны зарчмуудыг хэвшүүлэхэд банкны хяналт шалгалтыг сайжруулах, банкуудын сайн засаглалын хэрэгжилтэд олон нийтийн анхаарлыг хандуулах, том өмчлөгчийн өмчлөх хэмжээнд хязгаарлалт хийх шаардлагатай байна.

Манай улсын хөдөө орон нутагт амьдарч, ажиллаж буй малчид, төрийн албан хаагчид, тэтгэвэр авагчдын дийлэнх хэсэг нь малчны, цалингийн, тэтгэврийн зээлд хамрагдсан байдаг. Эдгээр зээлдэгчид банк санхүүгийн талаар мэдлэг боловсрол нимгэн байгаагаас шударга бус зээлжүүлэлтэд хамрагдаж байна. Иймээс банкуудаас олгож буй зээлийн нөхцөл, бодит хүүгийн түвшингийн талаарх зээлдэгчдийн ойлголтыг сайжруулж, чанаргүй зээлээс үүдэлтэй алдагдлаа зээлийн өндөр хүүгээр нөхөх явдлыг багасгах шаардлагатай байна.

Түүнчлэн зээлийн эрсдэл өндөр байгаа нь зээлийн хүү буурахгүй байхад нөлөөлж байна. Зээлийн эрсдлийг бууруулахад зээлийн мэдээллийн санг бүрдүүлэн зээл олгох үйл ажиллагааны зардал, хугацааг хэмнэх, аж ахуйн нэгжүүдийн өмчлөлийг ил тод болгож, нэг зээлдэгчид олгох зээлийн хэмжээ зохистой хязгаараас давах явдлыг зогсоох нь чухал ач холбогдолтой байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь зээлийн хүү буурах зах зээлийн орчныг бүрдүүлэхдээ захиргаадалтын аргаар бус харин зээлийн хүү буурахгүй, өндөр түвшинд тогтоход нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлж, үүний үндсэн дээр тэдгээр хүчин зүйлсийг арилгаж, эдийн засаг, санхүүгийн зах зээлийн таатай орчныг бүрдүүлж, бизнес эрхлэгчдийг дэмжихэд оршино.

Гурав. Хөтөлбөрийн үндсэн зарчим, зорилт, үйл ажиллагааны үндсэн чиглэл

Хөтөлбөрийн зорилгод хүрэхийн тулд дараахь зорилтуудыг тавьж байна.

1. Инфляцийг нам, тогтвортой түвшинд байлгах

- 1.1. Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшинг шат дараатайгаар бууруулах;
- 1.2. Хэрэглээний үнийн индексг голлох нөлөөтэй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлж, оновчтой хуваарилан, нийлүүлэлтийг жигд хангаж, үнийн хэлбэлзлийг бууруулах бодлого хэрэгжүүлэх;
- 1.3. Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Бургастай, Бичигтийн хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, хэрэглээний үнийн индексг голлох нөлөөтэй импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- 1.4. Төрийн мөнгөний болон төсвийн бодлогыг уялдаатай, мөчлөг сөрсөн байдлаар явуулж, инфляцийг нам, тогтвортой байлгах макро нөхцлийг бүрдүүлэх.

2. Банкуудын үйл ажиллагааны шударга, зохистой байдлыг хангуулах

- 2.1. Банкуудын зээлийн журам, түүний хэрэгжилтэнд үзлэг хийх. Хүү, шимтгэлийн зээлдэгчдэд үзүүлэх дарамтыг багасгах;
- 2.2. Банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах. Шударга өрсөлдөөнийг дэмжих;
- 2.3. Санхүүгийн зах зээлд оролцогчдын болон ялангуяа жижиг зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх;
- 2.4. Зээлийн мэдээллийн санг өргөтгөх ажлын хүрээнд төрийн эрх бүхий байгууллагатай холбогдох, тэдгээрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, түүнд банк, санхүүгийн байгууллагуудын нэвтрэх боломжийг бий болгох.

3. Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг хангах, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэх

- 3.1. Хөрөнгийн захын хөгжлийг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх;
- 3.2. Санхүүгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх;
- 3.3. Санхүүгийн захын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх, санхүүгийн захад оролцогчдын шударга өрсөлдөөнийг дэмжих;
- 3.4. Санхүүгийн зах зээлийн хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих. Жишиг хүү бий болгох болон чиглүүлэгч хүүг тогтоох, аж ахуйн нэгжүүдийн хөрөнгө босгох боломжийг нэмэгдүүлэх үүднээс Засгийн газрын үнэт цаасыг олон улсын болон дотоодын зах зээлд гаргаж байх. Чөлөөт эх үүсвэрийн удирдлагыг эрчимжүүлэх;
- 3.5. Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх. "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийг хэрэгжиж дуусах хүртэл том дүнтэй хадгаламжийн хүүний дээд хязгаарыг тогтоох бодлогын арга хэмжээг судлах;
- 3.6. Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд шүүхээс гадуур маргааныг шийдвэрлэх талаархи зохицуулалтыг илүү тодорхой болгох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах.

4. Санхүүгийн салбарын дэд бүтэц, хууль эрх зүйн орчинг сайжруулах

- 4.1. Банкны зээлийн барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн барьцаатай холбоотой хууль эрх зүйн орчинг сайжруулах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийн хэрэгжилтийг хангуулах;
- 4.2. Зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор зээлийн даатгал, баталгаа, батлан даалтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох хуулийг боловсруулж гаргах;
- 4.3. Хувь хүн болон компаний зээлийн түүхийн мэдээллийн сангийн найдвартай байдал, үйл ажиллагааг сайжруулж, түүний ашиглалтыг нэмэгдүүлэх;

ТӨСӨЛ

- 4.4. Монголд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн өмчлөлийг нийтэд ил тод болгох арга хэмжээ авах;
- 4.5. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн зохицуулалтад шинэчлэл хийх. Хиймэл хязгаарыг багасгах.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүргийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо хариуцан биелүүлнэ.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2011 оноос 2013 он хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн хүрэх үр дүн, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ. Үүнд:

- Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшинг 2011 онд нэг оронтой тоонд, 2012 онд 8 хувьд, 2013 онд 5 хувьд хүргэнэ.
- Банкуудын зээлийн журмуудын зохистой байдалд үзлэг хийж, дүгнэлт өгнө.
- Банкны зээлийн үйл ажиллагаанд шалгалт хийнэ.
- Санхүүгийн зах зээлд оролцогчдын болон ялангуяа жижиг зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.
- Зээлийн мэдээллийн сангийн хэрэглээ өргөжсөн байна.
- Санхүүгийн захад оролцогчдын ил тод байдал нэмэгдэнэ.
- Дунд, урт хугацаат эх үүсвэрийн хэмжээ нэмэгдэнэ.
- "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байна.
- Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд шүүхээс гадуур маргааныг шийдвэрлэх талаархи зохицуулалтыг илүү тодорхой болгох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьсан байна.
- Батлан даалтын сан байгуулагдах эрх зүйн орчин бүрдсэн байна.
- Аж ахуйн нэгжүүдийн өмчлөлийг нийт ил болгосон байна.

6.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлнэ. Үүнд:

ТӨСӨЛ

- Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны үнийн улирлын хэлбэлзлийг илэрхийлэх индекс;
- Шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх боомтын тоо;
- Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляци;
- Хөрөнгийн захын тогтвортой байдлын үзүүлэлтүүд;
- Санхүүгийн захын тогтвортой байдлын үзүүлэлтүүд.

Долоо. Хөтөлбөрийн тайлан, хяналт, шинжилгээ

Хөтөлбөрийн биелэлтийг жил тутам Улсын Их Хуралд Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороон тайлагнана.

ЗЭЭЛИЙН ХҮҮ БУУРАХ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРЧИНГ БҮРДҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

	Зорилт Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт Хүрэх үр дүн	Бусад бодлогын баримт бичигт тусгагдсан байдал	Хариуцах байгууллага	Хэрэгжүүлэх Хугацаа
1	ИНФЛЯЦИЙГ НАМ, ТОГТВОРТОЙ ТҮВШИНД БАЙЛГАХ				
1.1	Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшинг шат дараатайгаар бууруулах.	Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшинг 2011 онд нэг оронтой тоонд, 2012 онд 8 хувьд, 2013 онд 5 хувьд хүргэх	<i>Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.1 заалт</i>	"Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх бодлого баримтална."	МБ 2011-2013 онд
1.2	Хэрэглээний үнийн индекс голлох нөлөөтэй өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний нөөц бүрдүүлж, оновчтой хуваарилан, нийлүүлэлтийг жигд хангаж, үнийн хэлбэлзлийг бууруулах бодлого хэрэгжүүлэх.	Мах, махан бүтээгдэхүүн, сүү, сүүн бүтээгдэхүүн, хүнсний ногооны үнийн улирлын хэлбэлзлийг илэрхийлэх индекс	<i>ЗГҮАХ-ийн 2.1.12, 2.2.28, болон 2.3.1 дэх заалт; Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2 болон 5.4 заалт;</i>	"Хүн амын өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний эрэлт, нийлүүлэлтийн зохистой байдлыг хадгалж, нийлүүлэлтийг тогтворжуулж, инфляцийн түвшинг өсгөхгүй байх бодлогыг баримтлах" "Мах, сүүний бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоог бүрдүүлэх"	ЗГХЭГ, ХХААХҮЯ 2011-2013 онд

<p>1. 3</p>	<p>Замын-Үүд, Алтанбулаг, Гашуунсухайт, Шивээхүрэн, Булган, Бургастай, Бичигтийн хилийн боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, хэрэглээний үнийн индекст голлох нөлөөтэй импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах.</p>	<p>Шалган нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх боомтын тоо /7/</p>	<p>ЗГҮАХ –ийн 2.3.2 болон 4.3.5 дахь заалт;</p> <p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.3 заалт;</p> <p>ТМБҮЧ-ийг баталсан УИХ-ын 68-р тогтоол;</p> <p>ЗГ-ын 2010 оны 6 дугаар тогтоол;</p> <p>ЗГ-ын 2010 оны 102 дугаар тогтоол;</p>	<p>“Хүнсний бүтээгдэхүүний чанарыг шалгах орчин үеийн лабораторийг нийслэл болон хилийн боомтуудад ажиллуулна”</p> <p>“Хилийн шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хөрш орнуудын жишигт хүргэж, хилийн боомтын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.”</p> <p>“Боомтуудын хүчин чадлыг нэмэгдүүлэх, гадаад худалдааны эргэлтийг сайжруулах”</p> <p>“Хилийн зарим боомтын талаар авах арга хэмжээний тухай”</p> <p>“Боомтуудын ерөнхий төлөвлөгөө, концессын зүйлийн жагсаалт батлах тухай;”</p>	<p>ЗГХЭГ, ГХЯ, СЯ, ЗТБХБЯ,</p>	<p>2011-2013 онд</p>
-----------------	---	---	---	--	--	----------------------

1. 4	Төрийн мөнгөний болон төсвийн бодлогыг уялдаатай, мөчлөг сөрсөн байдлаар явуулж, инфляцийг нам, тогтвортой байлгах макро нөхцлийг бүрдүүлэх.	Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийг нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх. 2013 онд 5 хувиас доош хэмжээнд байлгах	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.1 заалт ЗГҮАХ–ийн 2.1.7 дахь заалт; Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.5 заалт; /Төсвийн тогтвортой байдлын тухай хууль/	"Дунд хугацаанд эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн нэг оронтой тооноос хэтрүүлэхгүй байх бодлого баримтална." "Төсвийн зарлагыг зохистой түвшинд хязгаарлан хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлж, төсвийг үр ашигтай байлгах бодлого баримтална. " "Дотоодын нийт бүтээгдэхүүнд нэгдсэн төсвийн урсгал зарлагын эзлэх хэмжээг бууруулах бодлого баримтлах. "	ЗГ, МБ	2011-2013 онд
2	БАНКУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ШУДАРГА, ЗОХИСТОЙ БАЙДЛЫГ ХАНГУУЛАХ					
2. 1	Банкуудын зээлийн журам, түүний хэрэгжилтэнд үзлэг хийх. Хүү, шимтгэлийн зээлдэгчдэд үзүүлэх дарамтыг багасгах.	Банкуудын зээлийн журмуудын зохистой байдалд үзлэг хийж, дүгнэлт өгөх.	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 заалт	"Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ"	МБ МБХ	2011 оноос

ТӨСӨЛ

2. 2	Банкны зээлийн үйл ажиллагаанд шударга бус хэлцэл үүсэх боломжийг хязгаарлах.	Банкны зээлийн үйл ажиллагаанд шалгалт хийснээр	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 заалт	"Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ"	МБ МБХ	2011 оноос
2. 3	Санхүүгийн зах зээлд оролцогчдийн болон ялангуяа жижиг зээлдэгчдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	Хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх			МБ СЗХ МБХ	2011 оноос
2. 4	Зээлийн мэдээллийн санг өргөтгөх ажлын хүрээнд төрийн эрх бүхий байгууллагатай холбогдох, тэдгээрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох, түүнд банк, санхүүгийн байгууллагуудын нэвтрэх боломжийг бий болгох	Зээлийн мэдээллийн сангийн хэрэглээний өргөжилт	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 заалт	"Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ"	МБ СЗХ АБ	2011
3	САНХҮҮГИЙН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДЛЫГ ХАНГАХ, ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙГ ТҮРГЭТГЭХ					

3.1	Хөрөнгийн захын хөгжлийг эрчимжүүлж, үр ашгийг нэмэгдүүлэх.	Хөрөнгийн захын тогтвортой байдлын үзүүлэлтүүдээр	<p>"Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ийн 5.1.3 заалт</p> <p>Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2011 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 2.1, 2.2, 2.3 заалтууд;</p> <p>Монгол улсын засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.1.22 дахь заалт</p>	<p>"Хөрөнгийн зах зээлийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох"</p> <p>"Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийг боловсронгуй болгож, Хөрөнгийн биржийн үйл ажиллагааг олон улын түвшинд ойртуулан хөгжүүлэх"</p> <p>"Монголын хөрөнгийн зах зээлд гадаадын үнэт цаасыг бүртгэх, арилжаалах эрхзүйн орчныг бий болгох"</p>	СЯ СЗХ ЗГХЭГ	2011, Дунд хугацаанд
3.2	Санхүүгийн зах зээлд оролцогчдын санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлэх.	Санхүүгийн захын тогтвортой байдлын үзүүлэлтүүдээр /FSIs/	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.1 заалт	"Банкны санхүүгийн чадавхийг бэхжүүлж, салбарын эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэн урт хугацаанд тогтвортой ажиллах нөхцлийг бүрдүүлнэ"	МБ СЗХ	2011 оноос
3.3	Санхүүгийн захын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн санхүүгийн сахилга батыг өндөржүүлэх.	Санхүүгийн захад оролцогчдын ил тод байдал нэмэгдэж буйгаар ...	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.2 заалт	"Банкны салбарын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангуулж, хяналт шалгалтыг цаашид сайжруулж, банкны зохистой засаглалын зарчмыг мөрдүүлэн	МБ СЗХ	2011 оноос

				салбарын санхүүгийн сахилга батыг өндөржүүлнэ		
3.4	Мөнгөний захын хөгжлийг түргэтгэж, дунд болон урт хугацаат эх үүсвэрийг нэмэгдүүлэх суурийг бүрдүүлэх, жишиг хүү болон өгөөжийн муруйг бий болгох үүднээс Засгийн газрын урт болон богино хугацаат дотоодын үнэт цаасыг тогтмол гаргаж байх.	Дунд, урт хугацаат бондын гаргалтыг нэмэгдүүлэх	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 1.4 заалт	"Монголбанк санхүүгийн зах зээл дээр урт хугацаатай эх үүсвэр бий болгох арга хэмжээ авна. Үнэт цаасны зах зээлийг өргөтгөн банкны салбарт үүссэн мөнгөн хуримтлалыг эдийн засгийн хөгжилд үр ашигтай ашиглах асуудлыг Засгийн газар, Санхүүгийн Зохицуулах Хороотой хамтран судлаж, холбогдох арга хэмжээ авна"	СЯ МБ СЗХ ХБ	2011 оноос
3.5	Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх. "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай" хуулийг хэрэгжиж дуусах хүртэл том дүнтэй хадгаламжийн хүүний дээд хязгаарыг тогтоох бодлогын арга хэмжээг судлах.	Хуулийг төслийг өргөн барих, батлуулах	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.3 заалт	"Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, өнөөгийн банкны нийтлэг үйлчилгээнээс гадна хөгжлийн болон хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг өргөжүүлэн, хөрөнгийн захын хөгжлийг дэмжинэ"	СЯ МБ СЗХ	2011 оноос

3.6	Үл хөдлөх хөрөнгийн барьцааны тухай хуульд шүүхээс гадуур маргааныг шийдвэрлэх талаархи зохицуулалтыг илүү тодорхой болгох чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах	Хуулийг төслийг өргөн барих, батлуулах	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.3 заалт	"Хадгаламжийн даатгалын тогтолцоог нэвтрүүлэх, барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, өнөөгийн банкны нийтлэг үйлчилгээнээс гадна хөгжлийн болон хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагаа эрхлэх эрх зүйн орчинг бүрдүүлж, санхүүгийн зах зээлийг өргөжүүлэн, хөрөнгийн захын хөгжлийг дэмжинэ"	СЗХ СЯ МБ	2011 оноос
4	САНХҮҮГИЙН САЛБАРЫН ДЭД БҮТЭЦ, ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХ					
4.1	Банкны зээлийн барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, үл хөдлөх хөрөнгийн барьцаатай холбоотой хууль эрх зүйн орчинг сайжруулах, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны хуулийн хэрэгжилтийг хангуулах.	Холбогдох хууль, эрх зүйн актуудад өөрчлөлт орсноор...	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2011 онд баримтлах үндсэн чиглэлийн 2.3 заалт	"... барьцаа хөрөнгийн хөрвөх чадварыг сайжруулах, ..."	МБ СЗХ	2011 оноос
4.2	Зээлийн эрсдлийг бууруулах зорилгоор зээлийн даатгал, баталгаа, батлан даалтын тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, холбогдох хуулийг боловсруулж гаргах	Батлан даалтын сан байгуулагдах эрх зүйн орчин бүрдсэнээр	ЗГҮАХ-ийн 2.1.24 дахь заалт	"Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдэд зээлийн баталгаа гаргах, зээлийн даатгал, барьцааны талаарх эрх зүйн үндсийг бүрдүүлнэ."	ЗГ	2011 оноос
4.3	Хувь хүн болон компаний зээлийн түүхийн мэдээллийн сангийн найдвартай байдал, үйл ажиллагааг сайжруулж, түүний ашиглалтыг	Холбогдох хууль, эрх зүйн актууд батлагдсанаар...			МБ СЗХ МБХ	2011

ТӨСӨЛ

	нэмэгдүүлэх					
4. 3	Монголд үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн өмчлөлийг нийтэд ил тод болгох арга хэмжээ авах	ААН-үүдийн өмчлөлийг нийт ил болгох			ЗГ СЗХ	2011

_____ооо_____

ТОВЧИЛСОН НЭРСИЙН ЖАГСААЛТ

ЗГХЭГ-	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР
ХХААХҮЯ-	ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
ГХЯ-	ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ
ЗТБХБЯ-	ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ
МБ-	МОНГОЛБАНК
СЯ-	САНГИЙН ЯАМ
СЗХ-	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ХБ-	ХӨРӨНГИЙН БИРЖ
МБХ-	МОНГОЛЫН БАНКУУДЫН ХОЛБОО
АБ-	АРИЛЖААНЫ БАНКУУД